

**2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн. ГССҮТ, УАУХТ эмнэлгүүд хүлээгдлийн мэдээ ирүүлээгүй байна.

**Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2019 оны 9 дүгээр сард СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна. Нийт хүлээгдэл 652 бүртгэгдсэн. Өдөртөө үйлчлүүлсэн 800 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Үүнд: УНТЭ 111 хүлээгдэл, УХТЭ 134 хүлээгдэл, УГТЭ 219 үйлчлүүлэгч, ХСҮТ 188 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн долоон кабинетэд 111 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 93 үйлчлүүлэгчийн хүлээгдээр нэмэгдсэн байна. Үүнд: Бөөрний кабинет 33, зүрх судасны кабинет 15, уушигний кабинет 1, мэдрэлийн кабинет 20, чих хамар хоолойн кабинет 11, булчирхайн кабинет 1, урологийн кабинетэд 12, хэрх үе судлал 18 хүлээгдэл 2 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 9 кабинетэд 134 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 5 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд: Бөөр судлалын кабинет 9, зүрх судасны кабинет 12, уушигны кабинет 4, мэс заслын кабинет 2, мэдрэл судлалын кабинет 10, чих хамар хоолойн кабинет 2, булчирхай судлалын кабинет 45, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 48, эмэгтэйчүүдийн кабинет 2 үйлчлүүлэгч тус тус 2-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетэд 237 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 6 кабинетэд нийт 219 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 99 хүлээгдлээр нэмэгдсэн байна.

Үүнд: Зүрх судасны кабинетэд 46, мэдрэлийн кабинет 26, чих хамар хоолойн кабинетэд 12, хоол боловсруулах эрхтэн системийн кабинет 30, цээжний хөндийн мэс засал 50, элэг цөс нойр булчирхайн кабинет 52, зүрхний мэс засал 15 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 17 кабинетэд 429 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 9 кабинетэд нийт 188 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 72 хүлээгдлээр нэмэгдсэн

байна. Үүнд: Зүрх судасны кабинет 35, мэс заслын кабинет 2, толгой хүзүүний мэс заслын кабинет 8, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 15, гепатологийн кабинет 29, туяа эмчилгээний кабинет 26, хими эмчилгээний кабинет 42, хөнгөвчлөх 2, ангиографийн кабинет 29 үйлчлүүлэгч тус бүр 2-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 134 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УНТЭ, УГТЭ-ийн 2019 оны 9-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 9-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



**Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:**

2019 оны 9 дүгээр сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад 525 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 499 үйлчлүүлэгч байна.

УНТЭ-т оношлуулахаар 91 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна.

Үүнд: Хэвлийн эхо 19, тархины цахилгаан бичлэг 4, доплерографи 22, MRI 1, бүдүүн гэдэсний дуран 27, КТГ 4, урологийн оношилгооны дуран 14 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 117 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд: Рентген зураг 38, зүрхний цахилгаан бичлэг 6, хэвлийн эхо 42, ходоодны дуран 18, доплерографи 13 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 173 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 80 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд: Рентген зураг 20, зүрхний цахилгаан бичлэг 25, хэвлийн эхо 35 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 112 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 297 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 84 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 58 үйлчлүүлэгч, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 140 үйлчлүүлэгч байна. 2 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэл 198 байна.

Үүнд: Ходоодны дуран 24, хэвлийн ЭХО 91, зүрхний цахилгаан бичлэг 33, бүдүүн шулуун гэдэсний дуран 3, рентген харалт 47 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 84 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 169 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 130 өдөртөө, 7 үйлчлүүлэгч 2 хоног, 3-14 хоногийн хүлээгдэлтэй 32 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. 2-6 хоногийн хүлээгдэлтэй 39 үйлчлүүлэгч байна.

ЭХЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетийн 9-р сарын  
хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:

Оношилгооны кабинетийн нэр	УНТЭ	УХТЭ	УГТЭ	ХСҮТ	СЭМҮТ	Нийт хүлээгдэл
Рентген шинжилгээ		38	20	47		105
Зүрхний цахилгаан бичлэг		6	25	33		64
Хэвлийн ЭХО	19	42	35	91		187
Тархины цахилгаан бичлэг	4					4
Ходоодны дуран		18		24		42
Бүдүүн гэдэсний дуран	27			3		30
Допплерографи	22	13				35
Зүрхний ачаалалтай сорил						0
Урологийн оношилгооны дуран	14					14
КТГ	4					4
МRI	1					1
Эмгэг сэтгэл судлал					39	39
<b>Нийт</b>	<b>91</b>	<b>117</b>	<b>80</b>	<b>198</b>	<b>39</b>	<b>525</b>

**Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 9 сарын лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**

2019 оны дүгээр сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

Лабораторийн нийт хүлээгдэл 285, өдөртөө үйлчлүүлсэн 591 үйлчлүүлэгч байна.


УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 181 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 8, шээсний ерөнхий шинжилгээ 21, биохими 112, бактериологийн шинжилгээ 27, иммунологийн шинжилгээ 4, сериологийн шинжилгээ 1, коагулограммын шинжилгээ 8 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 352 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн хүлээгдэл 105 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 24, биохимийн шинжилгээ 68, иммунологи 12 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Шээсний ерөнхий шинжилгээ, бактериологи, серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

Өдөртөө үйлчлүүлсэн 239 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 9-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



**Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2019 оны 9 дүгээр сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ ЭХЭМҮТ, НЭМГ бүртгэн мэдээлсэн.

Нийт хүлээгдэл 594 үйлчлүүлэгч хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. ЭХЭМҮТ, УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 9-р сард нийт 188 үйлчлүүлэгч 3 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 5, зүрх судасны системийн тасаг 29, уушигны тасаг 9, мэс заслын тасагт 109, мэдрэлийн тасагт 6, уламжлалт эмчилгээний тасагт 12, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 18 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 9-р сард нийт 152 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөр судлалын тасаг 4, зүрх судасны тасагт 19, чих хамар хоолойн тасагт 60, мэдрэлийн мэс засалд 63, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 6 үйлчлүүлэгч тус тус 3-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүсэн байна.

ХСҮТ-д 9-р сард нийт 231 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд 3-6 хоногийн хүлээгдэлтэй 70 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 98 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 53 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна. Элэг цөс нойр булчирхайн тасаг

40, мэс заслын тасагт 4, хөнгөвчлөх эмчилгээ 21, хими эмчилгээ 133, ангиограф 33 үйлчлүүлэгч 3-30 хоног хүлээж үйлчлүүлсэн байна

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн 9-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 23 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

Үүнд: 7 үйлчлүүлэгч 3-6 хоног, 16 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (2019 оны 9 сар):



**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харьяа 9 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн мэдрэл 57, дотор 117, ХУДЭМТ-ийн дотор 70, БЗДНЭ-ийн дотор 125, СХД-ийн ахмадын эмнэлэг 106 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 9-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.


**Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 9 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ**

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	9 сар									
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	СХД НЭ	
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	57	2	0	14	4	35	0	0	0	
		1-3 хоног	7	2		10		2				
		3-6 хоног	26			4	2	3				
		7-14хоног	17				2	30				
		15-30 хоног	7									
		1 сараас дээш										
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	117	70	46	28	0	33	125	0	0	
		1-3 хоног	14	16	24	10		2	5			
		3-6 хоног	22	31	15	7		4	5			
		7-14хоног	77	17	7	11		27	38			
		15-30 хоног	4	6					77			
		1 сараас дээш										
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	106	0	0	0	0	0	0	0	0	
		1-3 хоног	14									
		3-6 хоног	25									
		7-14хоног	11									
		15-30 хоног	56									
		1 сараас дээш										

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 9-р сард 25457 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 4777 дуудлагаар буурсан байна. Нийт дуудлагын 32.7%-ийг 0-20 минутад, 34.8%-ийг 21-40 минутад, 18.5%-ийг 41-60 минутад, 14.0%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 9 дүгээр сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 0.5%-иар нэмэгдсэн, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 3.2%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны сүүлийн 6 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ  
 МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА